

НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Улам бүр даяарчлагдаж буй өнөө үед дэлхий нийтийн чиг хандлага, тэр дундаа эрүүл мэндийн салбарт гарч буй өндөр дэвшилтэт технологи, түүний хүртээмж, тархах хурд өдрөөс өдөрт нэмэгдэж байна.

Эрүүл мэндийн салбарын эмчилгээ, оношилгоонд эмнэлгийн тоног төхөөрөмж чухал байр суурь эзэлдэг. Сүүлийн жилүүдэд Монгол улсын эрүүл мэндийн салбарт эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл ихээхэн хийгдэж байна.

Эрүүл мэндийн яамны захиалгаар 2010 онд гүйцэтгэсэн эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн ашиглалтын судалгаанд “Тоног төхөөрөмжийн хангалтын байдлыг 2005 онд хийгдсэн судалгаа болон 2001 онд Стандарт хэмжил зүйн үндэсний төвөөс гаргасан “Эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт”-тай харьцуулж үзэхэд сүүлийн 4 жилийн дотор нийт 25 орчим тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг 8 төрлийн эх үүсвэрээс санхүүжүүлэн нийлүүлж, нийт тоног төхөөрөмжийн хангамжийг 19%-иар нэмэгдүүлсэн байна” гэж дүгнэсэн байна.

Үүнийг дагаад эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын байдлыг судалж, ашиглалтыг дээшлүүлэх шаардлага гарч байгаа нь энэхүү судалгааны үндэслэл болж байна.

Зорилго: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээний сан үүсгэж, ашиглалтыг судлах

Зорилт:

- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээний сан үүсгэх
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг судлах

Судалгааны хүрэх үр дүн: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээний сан үүсэж, ашиглалтын өнөөгийн байдал тодорхойлогдон судалгааны ажлын тайлан бичигдэн, дүгнэлт зөвлөмж гарна.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд 21 аймгийн эрүүл мэндийн газар болон Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа байгууллагууд, ЭМСЯ-ны харьяа 14 төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийг хамруулахыг зорьсон. Гэхдээ судалгаа хийх үед зарим эрүүл мэндийн байгууллага мэдээллээ ирүүлээгүй тул мэдээлэл ирүүлсэн 297 эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа 26660 эмнэлгийн тоног төхөөрөмжийг хамруулсан.

Мэдээлэл цуглуулах хэрэгсэл: Судалгааны ажлын хүрээнд боловсруулсан асуумж маягтын дагуу судалгааг хийж гүйцэтгэн, мэдээллийг цуглуулсан бөгөөд мэдээллийг боловсруулахдаа ЭМЯ-наас 2010 онд хийгдсэн судалгаатай харьцуулж үзлээ.

Судалгааны удирдамж болон маягтыг 2015 оны 01 болон 05-р сард албан тоотоор 21 аймгийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар, ЭМСЯ-ны харьяа 14 төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хүргүүлсний дагуу цахимаар болон цаасаар мэдээлэл цуглуулан, сан үүсгэж, дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны бэрхшээл: Мэдээллийг цахимаар болон цаасаар авахад цахимаар авсан мэдээллийн үсгийн фонт танигдахгүй, цаасаар авсан мэдээллийг шивж оруулах зэрэг бэрхшээл гарсан. Үүнээс гадна судалгааны нэгтгэлийг хийхэд зарим эрүүл мэндийн байгууллага мэдээллээ ирүүлэхгүй, зарим ирүүлсэн байгууллагын мэдээллийн маягт өөр, эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэршил өөр өөр байсан зэрэг бэрхшээл учирч байсан.


ХОЁР. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамж, хэвийн ажиллагаа, засвар үйлчилгээний байдал, дэвшилтэт технологи бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийг судалснаар эмнэлгийн тоног төхөөрөмжийн талаарх асуудлыг шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлж өгөхөд тус дэмжлэг болох ач холбогдолтой юм. Үүний тулд шатлал тус бүрийн эмнэлгүүдэд одоо ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэсэн он, ашиглалтад орсон он, ашиглалтад орохдоо шинэ байсан эсэх, эх үүсвэр /ханган нийлүүлэгч/, хэвийн ажиллагаатай эсэх зэрэг үзүүлэлтээр судалж, дүнг нэгтгэн гаргалаа.

Үйлдвэрлэсэн улс

Эрүүл мэндийн байгууллагуудын ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэсэн улсаар ангилж үзэхэд дийлэнх хувь нь буюу 29%-ийг БНХАУ-д үйлдвэрлэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж эзэлж байгаа бөгөөд 2010 оны судалгаатай харьцуулахад энэ тоо 21%-иас 29% болж бага зэрэг өссөн байна. Харин 11%-ийг ОХУ-д үйлдвэрлэсэн эмнэлгийн тоног төхөөрөмж эзэлж байгаа бөгөөд 2010 оны судалгаатай харьцуулахад энэ тоо 38%-иас 11% болж буурсан байна. Түүнчлэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн голлох үйлдвэрлэгч улс орнуудаас гадна бусад улс орнууд 2010-2015 оны хооронд 10%-иас 34% болж өссөн байна. Энэ нь манай оронд хандив тусламж үзүүлэгч улс орнуудын тоо нэмэгдсэнээс гадна, ханган нийлүүлэгч байгууллага олон болж тэр хэмжээгээр өөр өөр улс орнуудын үйлдвэрлэгч, нийлүүлэгчтэй харьцах болсонтой холбоотой байна. Судалгаанаас харахад БНХАУ, ОХУ, БНСУ, ХБНГУ, Япон, АНУ орнуудаас гадна 40 орны эмнэлгийн тоног төхөөрөмжүүд ашиглаж байна.


Дүрслэл 1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгч улс орон



Үйлдвэрлэсэн он

Эрүүл мэндийн байгууллагуудын ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн 53% нь 2010-2015 онд, 33% нь 2000-2009 онд үйлдвэрлэгдсэн байна. Үүнээс харахад эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамжийн асуудалд ихээхэн анхаарал хандуулж хөрөнгө оруулалт хийх болсныг харуулж байна.


Дүрслэл 2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэсэн он



Ашиглалтад орсон он

Эрүүл мэндийн байгууллагуудын ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн 56% нь 2010-2015 онд, 32% нь 2000-2009 онд үйлдвэрлэгдсэн байна. Энэхүү үзүүлэлтийг 2010 оны үзүүлэлттэй харьцуулахад эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэн шинэчлэгдэж байгаа нь харагдаж байна.


Дүрслэл 3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтад орсон он



Ашиглалтад орохдоо шинэ байсан эсэх

Эрүүл мэндийн байгууллагуудын ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн 80% нь ашиглалтад орохдоо шинэ байсан, 7% нь хуучин байсан байна. Харин энэ асуумжийг хоосон орхисон нь 13% байна. Энэхүү үзүүлэлтийг харахад ихэнх эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглалтад орохдоо шинэ байсан байна.

Дүрслэл 4. Эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглалтад орохдоо шинэ байсан эсэх



Эх үүсвэр

Эрүүл мэндийн байгууллагуудын ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн 150 гаруй төрлийн эх үүсвэр ханган нийлүүлэгчдээс нийлүүлэгдсэн байна. Гэхдээ зарим тоног төхөөрөмжийн хувьд санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй, судалгаанд бөглөгдөөгүй нь 28% байна. Нийт эх үүсвэрийг эзэлж байгаа хувиар нь 6 ерөнхий ангилалд хуваан үзэхэд нийт тоног төхөөрөмжийн 59% нь Монгол улсын хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн байна. Харин гадаад улс орны буцалтгүй тусламжаар орж ирсэн тоног төхөөрөмж нь 6% байна. 2010 оны судалгаатай харьцуулахад хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна.


Дүрслэл 5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ханган нийлүүлсэн эх үүсвэр



Хэвийн ажиллагаатай эсэх

Эрүүл мэндийн байгууллагуудын ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн 80% нь хэвийн ажиллагаатай, 8% нь хэвийн бус ажиллагаатай байна. Харин энэ асуумжийг хоосон орхисон нь 12% байна. Энэхүү үзүүлэлтийг харахад ихэнх эмнэлгийн тоног төхөөрөмж хэвийн ажиллагаатай байна.

Дүрслэл 6. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал



ДҮГНЭЛТ

Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн ихэнх хувийг БНХАУ-д үйлдвэрлэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж эзэлж байгаа бөгөөд 2010 оны судалгаатай харьцуулахад энэ тоо 8%-иар өссөн байна.

Хангалтын байдлыг харахад сүүлийн 5 жил буюу 2010-2015 оны хооронд үйлдвэрлэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн 53%-ийг, ашиглалтад орсон нь 56%-ийг эзэлж байгаа нь эмнэлгийн тоног төхөөрөмж ихээхэн шинэчлэгдэж байгааг харуулж байна.

Монгол улсад нийлүүлэгдэн ашиглалтад орж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн 80% нь шинэ, 7% нь хандив тусламжаар орж ирсэн хуучин тоног төхөөрөмжүүд байна.

Судалгаанаас харахад хэвийн үйл ажиллагаанд оруулах шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж нь нийт эмнэлгийн тоног төхөөрөмжийн 8%-ийг эзэлж байна.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн санхүүжилтын эх үүсвэрийг харахад 59%-ийг Монгол улсын хөрөнгө оруулалтаар, 6%-ийг гадаад улс орны буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж эзэлж байгаа нь 2010 оны судалгаатай харьцуулахад хөрөнгө оруулалтын хэмжээ 15%-иар нэмэгдсэн байна.

Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн 80% нь хэвийн, 8% нь хэвийн бус үйл ажиллагаатай байна.

ЗӨВЛӨМЖ

Эрүүл мэндийн байгууллагуудад орон тооны эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер менежерийг ажиллуулан бүртгэлийн талаар бэлтгэн сургаж, чадавхжуулах.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээний нэгдсэн сантай болох ажлыг зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлэн, ашиглах, тогтмол шинэчлэл хийх тогтолцоог бий болгох.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах талаар сургалтын хэрэгцээг тодорхойлон эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч, эмч, мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, мэргэжлийн болон ашиглалтын ур чадварыг нэмэгдүүлэх.

Эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг олон янзаар нэрлэсэн нь бүртгэл, судалгаа, нэгтгэл хийхэд хүндрэл үүсгэж байсан. Мөн энэ алдаа нь эрүүл мэндийн байгууллагуудад, түүнчлэн эмнэлгийн бүртгэлийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэрэнд ч гарч байсан. Иймээс эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн нэршилтэй болох ажлыг системтэй зохион байгуулан, түүнийг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх, хэрэглээнд хэвшүүлэх арга хэмжээ авах.

Судалгаанаас харахад эмнэлгийн тоног төхөөрөмжийн сэлбэг болон дагалдах хэрэгсэл худалдан авах төсөв байдаггүй, мөн олдоц муу байдгаас нэгэнт худалдан авсан тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байна. Иймд ханган нийлүүлэгчийн засвар үйлчилгээ үзүүлэх болон сэлбэг хэрэгсэл нийлүүлэх гэрээнүүдийн хэрэгжилтийг тухайн эрүүл мэндийн байгууллага хянаж, мэдээллийг дараагийн гэрээ байгуулахдаа өмнөх үзүүлэлтийг харгалзан үзэж байвал дээрхи асуудлыг шийдэхэд тустай болно.